



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/358

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05/07 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.9, Чадварлаг багш, оюутан, сурагч дэд хөтөлбөрийн “Чадварлаг мэргэжилтэн-Шинэ ховдын ирээдүй” тэтгэлэг олгох журмын 4.3 дахь (Тэтгэлэг хүртэгч нь бакалаврын боловсрол эзэмших өдрийн ангид болон нарийн мэргэжлээр суралцаж буй энэхүү журмын 2.2, 2.3, 2.4 дэх заалтыг хангасан оюутан суралцагч байна) заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Жаргалант сумын иргэн Мягмардорж овогтой Цэлмүүнд Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хятад хэлний чиглэлээр суралцахад нь 1,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт зарцуулагдах 1,000,000 төгрөг (нэг сая)-ийг 2022 оны аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.2 дахь “Боловсролын салбарын дэд хөтөлбөрүүд” (“Чадварлаг багш, оюутан сурагч”) хөтөлбөр, төслөөс тооцож гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01ah 1813